



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/16/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2023 он</p>	<p>Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Д.Энхжаргал Утас: 99434344 Цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХУСЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГА З.ОНОЛБААТАР ТАНАА

2023.03.25 № 2/АД. _____
танай _____-ны № _____-т

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Чандмань сумын татварын орлогын гүйцэтгэл 1,314.4 сая төгрөгөөр биелж 41.7 сая төгрөгөөр тасарсан байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 5.7 сая, үйл ажиллагааны орлого 21.0 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая, газрын төлбөр 3.9 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.1 сая, байгалийн нөөц ашигласны төлбөр 2.2 сая төгрөгөөр тус тус орлого давж, хөрөнгийн орлого 2.1 сая, шууд бус орлого 41.2 сая, бууны албан татвар 0.5 сая, малын тоо толгойн албан татвар 51.9 сая, бусад татвар, төлбөр хураамж 0.7 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.8 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.4 сая, торгуулийн орлого 0.05 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 919.4 сая төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 4.9 сая төгрөг, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл 0.3 сая, байр ашиглалттай холбоотой зардал 1.8 сая, эд хогшил урсгал засварын зардал 1.1 сая, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0.2 сая, нийт 22.0 сая төгрөгийг хэмнэн зарцуулсан байна.

021020443

Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ЗДТГ-ын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон арга хэмжээний үзүүлэлтийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 18 өдрийн 24 тоот тогтоолоор 6 бүлэг 84 заалтаар баталж, байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн сумын ИТХ-ын хуралдааны 08/02 дугаар тогтоолоор хангалттай хэрэгжүүлсэн гэж дүгнүүлсэн байна..

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	864,742.1	610,275.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	79,022.7	115,697.6
33	АВЛАГА	587,031.4	391,582.1
34	УРЬДЧИЛГАА	5,170.0	10,450.0
35	БАРАА МАТЕРИАЛ	193,518.0	92,545.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,551,911.6	3,472,303.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,551,911.6	3,472,303.2
39200	Биет хөрөнгө	7,394,683.5	3,407,464.7
39300	Биет бус хөрөнгө	157,228.2	64,838.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,416,653.7	4,082,578.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	62,811.3	37,942.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,811.3	22,942.5
41300	Өглөг	47,811.3	22,942.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,000.0	15,000.0
42200	Урт хугацаат зээл	15,000.0	15,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,353,842.4	4,044,636.0
51	Засгийн газрын хувь оролцоо	8,353,842.4	4,044,636.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,418,049.9	994,354.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,418,049.9	994,354.0
51200	Хуримтлагдсан үр дүн	3,954,347.2	2,796,720.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,981,445.3	253,562.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,416,653.7	4,082,578.5

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,010,051.1	1,958,075.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	57,338.3	322,289.6
110	Орлогын албан татвар	47,847.6	193,315.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,847.6	193,315.5
113	Хөрөнгийн албан татвар	4,344.4	119,169.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,146.4	9,804.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,613,049.6	431,416.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,613,049.6	431,416.3

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,339,663.2	1,204,369.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,712,822.2	1,699,421.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,712,822.2	1,699,421.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,911,545.9	1,677,961.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,586,296.7	379,026.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,227.5	46,198.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,411.0	373,734.5
2104	Хангамж, бараа материалын зардал	270,259.0	355,225.6
2105	Нормативт зардал	192,281.7	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,730.8	4,481.8
2107	Томилолт, зочны зардал	4,809.0	3,443.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,229.1	6,712.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,301.0	509,139.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	801,276.3	21,459.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,297,228.9	258,654.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,983.8	4,488,394.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,280,245.1	-4,229,740.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,535,986.5	1,613,994.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	57,338.3	322,289.6
110	Орлогын албан татвар	47,847.6	193,315.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,847.6	193,315.5
113	Хөрөнгийн албан татвар	4,344.4	119,169.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,146.4	9,804.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,769.2	2,334.9
1181	Газрын төлбөр	363.4	4,709.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,013.7	2,760.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	178,805.3	87,335.6
120	Нийтлэг татварын бус орлого	178,805.3	87,335.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,299,842.8	1,204,369.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,165,235.0	1,217,744.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,165,235.0	1,217,744.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,335,632.9	1,156,782.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,582,926.3	377,980.3

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,520.5	47,044.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,358.6	373,602.0
2104	Хангамж, бараа материалын зардал	62,192.2	21,155.0
2105	Нормативт зардал	171,585.5	335.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,152.3	4,438.8
2107	Томилолт, зочны зардал	5,018.8	3,443.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,124.0	9,045.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,754.7	319,737.7
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	829,602.1	60,962.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	370,751.5	396,250.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	188,367.4	294,012.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	188,367.4	294,012.3
2200	Дотоод эх үүсвэрээр	188,367.4	294,012.3
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-188,367.4	-294,012.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-169,524.3	-65,562.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	169,524.3	65,562.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	12,859.8	36,674.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,162.9	79,022.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79,022.7	115,697.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Нэгтгэсэн нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,035,929.4	41,983.6	-4,315.7	7,073,597.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,120.4	0.0	0.0	2,120.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,038,049.8	41,983.6	-4,315.7	7,075,717.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,120.4	0.0	0.0	-2,120.4

8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,322,383.4	-28,429.8	-13,708.5	1,280,245.1
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,358,312.8	13,553.8	-18,024.2	8,353,842.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,358,312.8	13,553.8	-18,024.2	8,353,842.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-79,466.0	0.0	0.0	-79,466.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,278,846.8	13,553.8	-18,024.2	8,274,376.4
19	Тайлант үеийн үр дүн	-4,267,348.2	37,607.7	0.0	-4,229,740.4
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,011,498.6	51,161.6	-18,024.2	4,044,636.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,448,821.80	1,278,964.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	941,380.60	919,388.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,324.50	858,426.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,223.90	377,980.30
210101	Үндсэн цалин	261,966.70	249,036.00
210102	Нэмэгдэл	66,539.30	62,011.24
210104	Урамшуулал	11,025.40	29,057.92
210105	Гэрээт ажлын хөлс	39,692.50	37,875.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,397.90	47,044.73
210201	Тэтгэврийн даатгал	32,234.20	32,049.80
210202	Тэтгэмжийн даатгал	3,630.90	3,600.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,189.90	3,150.30
210204	Ажилгүйдлийн даатгал	758.70	749.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,584.20	7,494.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,416.10	373,601.97
210301	Гэрэл, цахилгаан	15,519.10	16,385.54
210302	Түлш, халаалт	357,300.60	356,205.56
210303	Цэвэр, бохир ус	2,596.40	1,010.87
2104	Хангамж, бараа материалын зардал	21,166.30	21,154.96
210401	Бичиг хэрэг	2,072.60	1,968.36
210402	Тээвэр, шатахуун	15,941.00	15,941.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,152.70	3,245.60
2105	Нормативт зардал	335.30	335.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	335.30	335.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,569.10	4,438.80
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	167.00	167.00
210604	Урсгал засвар	5,402.10	4,271.80

2107	Томилолт, зочны зардал	3,572.60	3,443.00
210702	Дотоод албан томилолт	3,572.60	3,443.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,263.40	8,054.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,065.40	7,065.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330.00	330.00
210803	Даатгалын үйлчилгээ	145.00	145.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145.00	55.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30.00	24.36
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	425.00	425.00
210807	Газрын төлбөр	123.00	9.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,379.90	22,373.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,029.90	22,025.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350.00	348.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,056.10	60,962.55
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	56,467.50	39,373.95
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	56,467.50	39,373.95
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,588.60	21,588.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,866.20	18,866.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,722.40	2,722.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	399,156.10	294,012.33
220001	Барилга байгууламж	237,348.90	230,266.08
221001	Их засвар	84,900.00	38,473.20
222001	Тоног төхөөрөмж	64,300.00	18,908.65
223001	Бусад хөрөнгө	12,607.20	6,364.40
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	108,285.10	65,562.85
230001	Эргэж төлөгдөх зээл	108,285.10	65,562.85
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,448,821.80	1,279,021.29
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,283,777.40	1,193,630.69
320001	Орон нутгийн төсвөөс	1,045,928.90	955,782.19
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	237,848.50	237,848.50
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	165,044.40	85,390.61
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	2,205.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	83,185.61
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,439.40	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	64,439.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	64,496.58
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	106.00	104.00

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	50.00	49.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	20.00
620004	Гэрээт ажилтан	9.00	9.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	50.00	49.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26.00	25.00
650010	Гэрээт ажилтан	5.00	5.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	251,823.6	298,355.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	229,123.6	298,355.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,407.9	298,355.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,990.4	0.0
210102	Нэмэгдэл	23,990.4	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,784.5	0.0
210401	Бичиг хэрэг	1,198.7	0.0
210402	Тээвэр, шатахуун	3,714.1	0.0
210403	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	871.7	0.0
2105	Нормативт зардал	74,196.6	0.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,196.6	0.0
210502	Хоол, хүнс	4,000.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,587.5	991.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,587.5	991.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,848.8	297,364.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,684.8	297,364.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,164.0	298,355.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,715.7	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,207.7	0.0
213202	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,607.7	0.0
213203	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,600.0	0.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,508.0	0.0

213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,478.5	0.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,029.4	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,700.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	22,700.0	0.0
223001	Бусад хөрөнгө	22,700.0	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	251,823.6	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	251,823.6	298,355.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,201.7	3,960.0
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,700.0	287,973.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	112,197.2	4,751.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,489.3	1,670.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	106,235.5	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Чандмань сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн "Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх" эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон дараах зорилгыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн 17-р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд хяналт тавин ИТХ-ийн хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийг шийдвэрийн дагуу устгах ажлыг хариуцан ажиллаж жилийн ажлыг 88.7 хувьтай дүгнүүлсэн байна. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2022 оны 12 сарын 30-нд хуралдаж сумын хэмжээнд 122 нэр төрлийн 611.3 сая төгрөгийн хөрөнгө орлого авахаар шийдвэрлэжээ. Тайлант онд актлах хөрөнгө байхгүй гэж үзсэн байна.

Чандмань сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,334.1 сая төгрөгөөр буюу 48.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	79.0	115.7	36.7	1.5
Авлага	587.0	391.6	-195.4	0.7
Урьдчилгаа	5.2	10.4	5.2	2.0
Бараа материал	193.5	92.5	-101.0	0.5
Үндсэн хөрөнгө	7551.9	3472.3	-4,079.6	0.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8416.6	4082.5	-4,334.1	0.5
Богино хугацаат ер төлбөр	62.8	37.9	-24.9	0.6
Цэвэр хөрөнгө, өмч	8353.8	4044.6	-4,309.2	0.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8416.6	4082.5	-4,334.1	0.5

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/	
			Өөрчлөлт	
Төрийн сангийн харилцах	79.0	115.7	36.7	1.5
ДҮН	79.0	115.7	36.7	1.46

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 79.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 115.7 сая төгрөг болж 36.7 сая төгрөгөөр буюу 46.4 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь сум хөгжүүлэх төслийн зээл олгоогүй, хуучин зээлийн төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 391.6 сая төгрөг болж, өмнөх оноос 195.4 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь ажиллагсадтай холбоотой авлага 16.1 сая, төлбөртэй үйлчилгээний авлага болох ЭМД-ын санхүүжилтийн 63.5 сая, байгууллагаас авах авлагад Тамгын газарт тоглоомын талбай хүлээж авсан 71.9 сая төгрөг, сургууль дээр 27.4 сая төгрөгийн

компьютер тоног төхөөрөмжийг хөрөнгөнд бүртгэж хүлээж авсан тул 100.8 сая төгрөгөөр тус тус авлага буурсан.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	16.20	0.1	(16.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	63.80	0.3	(63.5)
Байгууллагаас авах авлага	100.90	0.1	(100.8)
Хувь хүмүүсээс авах авлага	15.00	22.2	7.2
Зээлийн хүүгийн авлага	382.2	362.5	(19.7)
Дансны авлага /ОНӨААТҮГ/	6.2	6.2	-
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	0.3	0.3	-
Татаас санхүүжилтийн авлага	2.4	-	(2.4)
Дүн	587.0	391.7	(195.3)

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нээгээсэн тайлан

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 10.4 сая төгрөг болж, өмнөх оноос 5.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	4.2	10.4	6.2
Цалингийн урьдчилгаа	1.0	0	(1.0)
Дүн	5.2	10.4	5.2

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нээгээсэн тайлан

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 92.5 сая төгрөг болж 101.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Түүхий эд материал	8.7	0.0	-8.7	0.0
Эм боох материал	8.7	0.0	-8.7	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0.0	0.0	0.0	0.0
Хангамжийн материал	184.8	92.5	-92.3	0.5
Бичиг хэргийн материал	1.8	1.3	-0.5	0.7

Аж ахуйн материал	63.1	0.7	-62.4	0.0
Түлш шатах тослох материал	1.6	0.0	-1.6	0.0
Барилгын засварын материал	0.3	0.0	-0.3	0.0
Хүнсний материал	27.2	0.0	-27.2	0.0
Бусад хангамжийн материал	23.5	23.2	-0.3	1.0
Мал амьтад	67.3	67.3	0.0	1.0
Нөөцийн бараа	0.0	0.0	0.0	1.0
Нийт бараа материал	193.5	92.5	101.0	0.5

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 65.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, хандиваар 0.9 сая төгрөг, бусад 27.7 сая төгрөг нийтдээ 103.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 91.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, 113.1 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансаж шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7551,9 сая төгрөг байсан бол оны эцэст 3472,3 сая төгрөг болж 4079.6 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд болох Цэцэрлэг, Эмнэлэг, Сургууль, Соёлын төвийн урсгал зардал улсын төсвөөс шууд санхүүжих болсонтой холбоотой үндсэн хөрөнгө бараа материалын үлдэгдэл 4488.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн. Мөн тайлант онд 175.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 62.8 сая, эцсийн үлдэгдэл 37.9 сая төгрөг болж 24.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч тэжээл бэлтгэсэн, ажилчидтай холбоотой 4.0 сая, бараа үйлчилгээний зардлын 29.4 сая төгрөгийн өглөг бүрэн барагдаж, байгууллагад төлөх өглөг 8.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8353.8 сая төгрөг байснаас оны эцэст 4044.6 сая төгрөг болж 4309.2 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд болох Цэцэрлэг, Эмнэлэг, Сургууль, Соёлын төвийн урсгал зардал улсын төсвөөс шууд санхүүжих болсонтой холбоотой үндсэн хөрөнгө бараа материалын үлдэгдэл, авлага өглөг, засгийн газрын сан балансаас балансад шилжсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1418.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1418.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1318.7 сая

төгрөгөөр анх баталж, сумын ИТХ-н тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орлогыг 100.0 сая төгрөгөөр баталж, 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны 7/02 тоот тогтоолоор нийт 1482.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 6/09 тоот тогтоолоор 1482.8 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1448.8 сая төгрөгийн төсөв баталснаас 955.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 237.9 сая төгрөгийг ОХНС-аас, 85.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 2.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 83.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлжээ.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Санхүүжилтийн эх үүсвэр	/сая төгрөгөөр/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,283.80	1,193.70
Орон нутгийн төсвөөс	1,045.90	955.80
Орон нутгийн хөгжлийн сан	237.90	237.90
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	165.00	85.30
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.60	2.20
Туслах үйл ажиллагааны орлогоос	108.30	83.10
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	56.10	
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	1,448.80	1,279.00

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 955.8 сая, ОНХС-ийн санхүүжилт 237.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.2 сая, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, өвсний авлагаас 83.2 сая, нийт 1,279.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 919.4 сая төгрөгийг зарцуулж, хөрөнгийн зардалд 294.0 сая, эргэж төлөгдөх сум хөгжүүлэх сан болон Чандмань хөгжил сангийн зээл 65.5 сая, 3.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 919.4 сая төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1.2 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 1.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0.2 сая, байр ашиглахтай холбоотой зардал 1.8 сая, урсгал шилжүүлэг 17.1 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгоогүй, нийт 22.0 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 100.0 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 2.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоос сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 41.9 сая, өвс тэжээлийн үнэ 10.0 сая, Чандмань хөгжил сангийн 31.3 сая, нийт нийт 85.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 16.8 сая төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлого тасарч, сум хөгжүүлэх сангийн программын үнэ 0.1 сая, компьютер авсан 1.5 сая, Чандмань хөгжил сангаас нягтлан бодогчид урамшуулал 0.8 сая нийт 2.4 сая төгрөгийн зардал санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын ангилал	/сая төгрөгөөр/	
	2022 оны	Зөрүү

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	379,251.50	324,839.63	52,151.45
Нийт орлого ба тусламжийн дүн	379,251.50	324,839.63	52,151.45
Татварын орлого	376,646.50	322,289.63	52,096.45
Хувь хүний орлогын албан татвар	181,773.70	174,380.21	7,393.49
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	129,490.00	135,267.39	(5,777.4)
Үйл ажиллагааны орлого	4,083.70	32,142.43	(28,058.7)
Шууд бус орлого	48,200.00	6,970.39	41,229.6
Хөрөнгийн албан татвар	190,500.00	138,104.80	52,395.20
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,300.00	3,442.79	(2,142.8)
Бууны албан татвар	3,000.00	2,528.00	472.0
Малын тоо толгойн албан татвар	165,200.00	113,298.71	51,901.3
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	21,000.00	18,835.30	2,164.7
Бусад татвар, төлбөр, хураамж	4,372.80	9,804.62	(5,431.82)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,100.00	2,334.89	765.11
Улсын тэмдэгийн хураамж	1,000.00	1,504.65	(504.7)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	1,100.00	255.24	844.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,000.00	575.00	425.0
Газрын төлбөр	772.80	4,709.31	(3,936.51)
Газрын төлбөр	772.80	4,709.31	(3,936.5)
Дуудлага худалдаа	-	5.33	(5.3)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	500.00	2,760.42	(2,260.42)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	200.00	395.00	(195.0)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	300.00	2,365.42	(2,065.4)
Татварын бус орлого	2,605.00	2,550.00	55.00
Нийтлэг татварын бус орлого	2,605.00	2,550.00	55.0
Торгуулийн орлого	2,000.00	1,945.00	55.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	605.00	605.00	-

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт татварын орлого 324.8 сая төгрөгөөр биелж 52.1 сая төгрөгөөр тасарсан байна. Орлого тасарсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 7.4 сая, шууд бус орлого 41.2 сая, хөрөнгийн албан татвар 52.4 сая, малд ногдуулах албан татвар 51.9 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 2.1 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал

ашигласны төлбөр 0.8 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.4 сая төгрөгөөр тус тус тасарч, Цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 5.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 28.0 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.1 сая төгрөг, байгалийн нөөц ашигласны төлбөр 2.2 сая, бусад татвар төлбөр хураамж 5.4 сая, газрын төлбөр 3.9 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс дулааны өр 249.5 сая төгрөг, Шим –Ус ОНӨААТҮГ-аас 3.9 сая төгрөг, аймгийн ОНХСангаас хог цэвэрлэгээ болон ХО-н барьцаа 24.1 сая, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 10.8 сая төгрөг, статистикийн хэлтсээс 0.9 сая төгрөг, ИТХ-аас хүүхэд хамгааллын багт 0.3 сая, шүлхийн дархлаажуулалтын зардал 7.8, Спортын тэмцээний шагнал 1.0 сая, нийт 287.9 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Энжаргал 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн 1/46 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,699.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 33.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 27.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ-нь байгууллагын төсвөөс 0.3 сая төгрөгийн хэвлэл, захиалгын зардал гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд төндөрт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүлээ. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт барагдаж, 172.3 сая төгрөгийн 3 албан шаардлагаас 79.8 сая төгрөгийн 2 биелж, 160.0 сая төгрөгийн 10 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Нийтдээ 72.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/сая төгрөгөөр/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1.0	1	1.0	-	-	100.0
Албан шаардлага	3	172.3	2	79.8	1	92.5	46.3
Зөвлөмж	10	160.0	10	160.0	-	-	100.0
Нийт дүн	14	333.3	12	240.8	2	92.5	72.2

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 69.8 сая төгрөгийн малжуулах төслийн зээлийн хугацаа хэтэрсэн авлагыг, мөн Сум хөгжүүлэх сангийн 2011-

2019 онуудад олгогдсон он дамжиж олон жил болж байгаа 18 зээлдэгчтэй холбоотой 55.5 сая төгрөгийн авлагыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44.7 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгуулах 4 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн 18.0 сая төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг "Отрын гэр"-г данс бүртгэлд бүртгээгүй зөрчил нь *Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 6 дугаар зүйлийн 6.4 Сум өөрийн Орон нутгийн сангаар дараах чиг үүргийг бие даан хэрэжүүлнэ: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2 "хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл арга хэмжээ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ заалтуудтай нийцэхгүй байна.*

Өгсөн зөвлөмж : 2023 оны эхний хагас жилд 2022 онд нийлүүлсэн 6 ширхэг отрын гэрийг данс бүртгэлд хөрөнгөөр бүртгэх

5.1.2 Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Сумын Тамгын газар нь Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулалт цалин 3.5 сая төгрөгөөс 0.8 сая, 2022 оны 1.2.3 дугаар улиралд багийн төвийн манаач нарт олгосон 3.9 сая төгрөгийн цалин урамшууллаас 0.9 сая төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл тооцож төлөөгүй нь *Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 32 дугаар зүйлийн 32.1.2 "иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс"-г зөрчсөн байна.*

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлж байгууллагатай тооцоо хийх

5.1.3 Авлагын данстай холбоотой

Илрүүлэлт: "ОНХсан, Тамгын газрын балансад бүртгэлтэй 45.0 сая өвсний авлагыг няравтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил нь *нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудтай нийцэхгүй байна.*

Өгсөн зөвлөмж: ЗДТГ-ь бүртгэлтэй өвсний авлагын тооцоо хийж авлагыг 2023 ондоо багтаан барагдуулж ажиллах

5.1.4 Татвар И баримттай холбоотой

Илрүүлэлт: ОНХС-н санхүүжилтээр Цэцэрлэгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр Сутайн бүлтгэр булаг ХХК-д 15.0 сая, мөн Хөх сүрэг ХХК-д өвс нийлүүлэхээр олгосон 10.0 сая санхүүжилтийг олгоходоо И баримтгүй гүйлгээ хийсэн, татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 25.0 сая төгрөгийн зөрчил байгаа нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."*, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."

Өгсөн зөвлөмж: Цаашид И баримтгүй ажил гүйлгээ гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулалт шимтгэл тооцож төлөөгүй	1	1.7			1	1.7
Тайлант онд ОНХСангаас санхүүжүүлсэн 18.0 төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг гэрийг данс бүртгэлд тусгаагүй	1	18.0			1	18.0
Орон нутгийн хөгжлийн сан, Тамгын газарт бүртгэлтэй өвсний тооцоо хийж авлага барагдуулах	1	0			1	0
И баримтгүй гүйлгээ хийсэн	1	25.0			1	25.0
Дүн	4	44.7	-	-	4	44.7

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Д.ЭНХЖАРГАЛ

ААБ 2.5: АУДИТЫН УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Төсвийн захирагчийн нэр:	Ховд Чандмань сумын ЗДТГазар
Уулзалт хийсэн газар, огноо, цаг:	2022.03.10-ны өдрийн 13.00 минут
Уулзалтын зорилго:	2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх талаар
Уулзалтад оролцогчдын албан тушаал, нэр:	Шалгагдагч байгууллагын талаас:
	Дарга: З.Онолбаатар
	Ня-бо: С.Цэрэнханд
	Төрийн аудитын байгууллагын талаас:
	Аудитор Д.Энхжаргал Аудитын менежер А.Цэцэгсүрэн
Уулзалт, ярилцлагын товч утга:	2022 оны санхүүгийн тайланд аудит хийх хуваарь, багийн бүрэлдэхүүн, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг танилцуулав. Мөн 2022 онд ТАБ-аас хэрэгжүүлсэн аудитын дүн, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын онцлог, өмнөх оны аудитын зөрчил, хэрэгжилтийг товч танилцуулж аудитын ажлын нөхцлийг тохиров. Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаа, гадаад, дотоод хүчин зүйл, нягтлан бодох бүртгэлийн бодлого, төсөв, санхүү, хөрөнгөнд гарсан үндсэн өөрчлөлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын талаар асууж тодруулав.
Шийдвэрлэсэн асуудлын агуулга:	Аудитад хамрагдах тайлан, баримт материалыг саадгүй гаргаж өгөх, ажиллах нөхцөл бололцоогоор хангах талаар тохиролцов.
Уулзалтын тэмдэглэл хөтөлсөн:	 Д.Энхжаргал
Танилцсан:	 Ня-бо: С.Цэрэнханд

НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛСАН БАРИМТ

Аудитын нэр: Ховд аймгийн Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХОА-2022/ 11/НА/-СТА-ТШЗ

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т "Нөлөөллийн мэдүүлэг" гэж аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан Төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг ойлгоно гэж заасан.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй Төрийн аудитын байгууллагын албан хаагчид аливаа этгээдээс нөлөөлсөн бүх үйлдэлд Төрийн аудитын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу "Нөлөөллийн мэдүүлэг" хөтөлнө.

Нөлөөллийн мэдүүлэгт дурдсан мэдээллийг шалгуулах, хуульд заасан хариуцлага ногдуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудитор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлж, энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүрд нь нийтэд мэдээлнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.9-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Нэг. Шалгагдагч этгээдийг төлөөлж:

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг	Огноо
1	Дарга	З.Онолбаатар		2023.03.10
2	Нягтлан бодогч	С.Цэрэнханд		2023.03.10

Хоёр. Төрийн аудитын байгууллагыг төлөөлж:

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг	Огноо
1	Аудитор	Д.Энхжаргал		2023.03.10
2	Аудитын менежер	А.Цэцэгсүрэн		2023.03.10
3	Тэргүүлэх аудитор	Х.Болдбаатар		2023.03.10

847143802
ПНОА0073 9366434